




МОНЭС
МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН




2008
ЖИЛИЙН
ТАЙЛАН

8

Биднийг дэмждэг байгууллагуудад
ТАЛЛАРХАЛ ДЭВШҮҮЛЬЕ!



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



Ford Foundation



Koninkrijk der Nederlanden

АГУУЛГА

Мэндчилгээ	4
МОНЭС-ийн эрхэм зорилго, зорилт	5
Шинээр хийгдсэн ажлууд	7
Тэтгэлэг олгох хөтөлбөр	
Хэрэгжсэн төслүүдийн амжилтаас	9
2008 оны тэтгэлэгийн санхүүжилт	12
Сан бүрдүүлэх хөтөлбөр	
Сан бүрдүүлэлтийн үйл ажиллагаа	14
Олон улсын сүлжээ, хамтын ажиллагаа	20
Хамт олон	21
Санхүүгийн тайлан	22
Хандивлагчдын нэрс	24
Хандив өргөх хүудас	30



МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм найзүүд аа!

Олон сайхан үйл явдлаар дүүрэн нэгэн жилийг бид ардаа орхиж байна. Монголын Эмэгтэйчүүдийн сангийн үйл ажиллагаа олон филантропчдын үзүүлсэн дэмжлэг туслацаа, өргөсөн хандивын ачаар урьд өмнө байгаагүйгээр цар хүрээгээ тэлж, алсыг харсан зорилдоо хүрэхэд нэгэн алхмаар ойртлоо.

Бидний өгсөн тэтгэлэг бүр эмэгтэйчүүдийн амьдралд өөрчлөлтийг авчрахыг зорьдог учраас эмэгтэйчүүдийн бүлгүүдийн хэрэгжүүлж буй төслүүдийг үр дүнтэй болгохын тулд ихээхэн хүч хөдөлмөр зарцуулан ажиллалаа. Ялангуяа, эмэгтэйчүүдийн байгууллага, бүлгүүдийн удирдагчдыг чадваржуулах явдал бидний хувьд чухал хэвээр байна. Тэдэнд итгэж, бас хөгжүүлж чадвал ихээхэн амжилт гаргах томоохон нөөц болохыг олж харсан юм. Үүний үр дүнд хэд хэдэн аймагт эмэгтэйчүүдийн байгууллагуудын сүлжээ үйл ажиллагааныхаа эхлэлийг тавьж, ажлын байран дахь бэлгийн дарамтлалтай тэмшэх, давхар хамаарлтай эмэгтэйчүүдийн бүлгүүдтэй ажиллах эвсэл, холбоод үйл ажиллагаагаа өргөжүүллээ.

Мөн 2008 онд Парламентын болон орон нутгийн сонгууль болж шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх асуудал ч бидний анхаарлын төвд байлаа. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь нийгмийн хөгжилд чухал ач холбогдолтой учраас Манлайлагч Эмэгтэйчүүдийн Үндэсний Чуулга уулзалт зохион байгуулахад санхүүжүүлэгч нь байж улс орны нийгмийн асуудлууд, эмэгтэйчүүдийн эрхийн асуудлуудад манлайлагч эмэгтэйчүүдийн анхаарлыг хандуулж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд оролшохын ач холбогдолыг хэлэлцэн ярьсаны үр дүнд урд хожид байгаагүй олон эмэгтэйчүүд Парламент болон орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн юм.

Орон нутгийн сонгуульд амжилт үзүүлэх боломжийг бид нээхийг эрмэлзсэн. Бидний сонгож чадавхжуулахын төлөө хөрөнгө оруулсан аймгуудаас Завхан аймагт Иргэдийн төлөөлөгчдийн хуралд 9 эмэгтэй сонгогдсон нь нийт төлөөлөгчдийн 29, 0 хувийг эзэлж, Засаг даргын орлогч болон 4 сумын засаг даргаар эмэгтэйчүүд томилогдсон зэрэг нь улсын хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт болж чадсан байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх явдал бидний хамгийн гол зорилт хэвээр байсаар байна. Эмэгтэйчүүдийн байгууллага, бүлгүүд хамтран ажилласнаар эмэгтэйчүүдийн оролцоотой нийгмийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд хүчээ нэгтгэх нь хүний эрхийг хангах хамгийн үр дүнтэй хамтын ажиллагааны хэлбэр болж байна.

Бид цаашдаа хөрөнгө оруулалтыг улам нэмэгдүүлж стратегийн дагуу бүсчилсэн хөгжлийн асуудал, өөрөөр хэвлэл өмнө нь сонгосон бүсийн төвүүдийг чадваржуулахын зэрэгцээ бусад аймгийн эмэгтэйчүүдийн байгууллагууд бүсээрээ хөгжих боломжийг нээсэн тэтгэлэгүүдийг олгоно. Мөн залуу эмэгтэй манлайлагчдын асуудалдаа анхаарлаа хандуулах болно. Хойч үеийг бэлдэх нь бидний эрхэм үүрэг билээ.



Ш. Цэвэлмаа
Тэргүүн
МҮ-ын Анхны
Тэргүүн Хатагтай



Н.Чинчuluун
Захирал

Биднийг дэмжиж,
итгэж, хамт
байдаг бүх
хүмүүстээ дахин
дахин талархсанаа
илэрхийлье.



Бидний зорилт бол

- ❖ Монголын эмэгтэйчүүдийн хөдөлгөөний тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах.
- ❖ Эмэгтэйчүүдийн хүний эрх, жендерийн тэгш эрхийг баталгаатай хангахад ахиц гаргах.
- ❖ Эмэгтэйчүүдийн төлөө хандивлагч байх филантропи соёлыг түгээхийг зорьдог.

МОНЭС ЯАГААД БАЙГУУЛАГДСАН БЭ?

- ❖ Эмэгтэйчүүд хөгжлийн гадна үлддэг учраас,
- ❖ Эмэгтэйчүүд нийгмийг дэвшилттэй өөрчлөх шинэ санаагаа хэрэгжүүлж чадахгүй байгаа учраас,
- ❖ Эмэгтэйчүүдийн бүлгүүд олноор байгуулагдсан ч тогтвортой хөгжиж чадахгүй байгаагаас,
- ❖ Дэлхийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөний хөгжлийн хөтөлбөрүүд манай эмэгтэйчүүдэд дутуу хүрч байдгаас.

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН /МОНЭС/-ийн түхай

ЗОРИЛГО + ҮЙЛ АЖИЛЛАГАА + НӨЛӨӨЛӨЛ + ҮР ДҮН = НИЙГМИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨӨ ТӨСЛҮҮДЭД САНХҮҮЖИЛТ ОЛГОНО.

ТАНИЛЦУУЛГА

Монголын Эмэгтэйчүүдийн Сан 2000 онд байгуулагдсан ба улс төрийн нам, эвсэлээс хараат бус, ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг олон нийтийн сан юм.

- Манай сан нийгэмд үйлчилдэг
- ❖ Эмэгтэйчүүдийн ТББ,
 - ❖ Эмэгтэй удирдагчтай хүний эрхийн ТББ,
 - ❖ Үүсгэл санаачлагын бүлгүүдийн эмэгтэйчүүдийн эрх,
 - ❖ Эмэгтэйчүүдийн оролцоо, хөгжлийг хангахын төлөө үйл ажиллагааг дэмжиж санхүүгийн буцалтгүй тэтгэлэг олгодог филантропи /нийгмийн төлөө өөрчлөлтийн мөнгөн туслалцаа үзүүлдэг/ байгууллага юм.

Бидний уриа

Эмэгтэйчүүдэд хөрөнгө оруулснаар гэр бүл,
нийгэмд хөгжил дэвшил ирнэ.

Эрхэм зорилго

Монголын Эмэгтэйчүүдийн хөгжил дэвшилийн
төлөө нөөц баялагийг хуримтлуулж
санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

БИДНИЙ ИТГЭЛ, ҮНЭТ ЗҮЙЛС:

- ❖ Эмэгтэйчүүд хүчтэй, чадвартай.
- ❖ Эмэгтэйчүүд нэгдсэнээр амжилтанд хүрнэ.
- ❖ Хүний эрхийг жинхэнэ ёсоор дээдэлсэн шударга, ардчилсан иргэний нийгмийг Эмэгтэйчүүдийн оролцоо, хандивгүйгээр төсөөлж үл болно.
- ❖ Эмэгтэйчүүд нийгмийг өөрчилж чадна.
- ❖ Ил тод, шударга ёсонд итгэдэг.
- ❖ Хүн бүхэн бусдын сайн сайхны төлөө хандивлагч байж чадна.

ШИНЭЭР ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХАНДИВЛАГЧДЫН “ТАНИЛЦАХ АЯЛАЛ”

Дотоодын хандивлагчдын санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилттэй танилцах аялалыг зохион байгууллаа. Танилцах аялалд 30 гаруй хандивлагч хувь хүн, байгууллагын төлөөлөгчид оролцож “Өрх тэргүүлсэн олон хүүхэдтэй эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлүүлж чадваржуулах нь” төслийн уралдаанд шалгарч санхүүжилт авсан эмэгтэйчүүдийн бүлгүүдийн хэрэгжүүлж байгаа төслүүдийн үйл ажиллагаатай танилцсан юм. Хандивлагчдын мөнгөн тусlamж эмэгтэйчүүдийн аж амьдралд хэрхэн хувь нэмэр оруулсныг хандивлагчид болон тэтгэлэг авагчид хэлэлцэн ярилсан нь бие биедээ итгэх итгэлийг нэмэгдүүлсэн ажил боллоо.



Хандивлагч С.Дондов:

“Монголын эмэгтэйчүүдийн сан байгуулагдсан үеэс эхлэн үйл ажиллагааг нь дэмжиж хандив

өргөж ирсэн. Бидний хандивласан мөнгийг эмэгтэйчүүдийн байгууллага бүлгүүдэд хэрхэн өгдөг, түүнийхээ заршуулалтанд хэрхэн хяналт тавьж байгаатай танилцаж, бодит ажил болсоныг хархад таатай байна. Хандивласан мөнгийг хэрхэн заршуулсныг ил тод харуулж байгаа нь цаашид хандивлагчдын тоог нэмэгдүүлнэ гэдэгт итгэж байна.”



ХАНДИВЛАГЧИД, ТЭТГЭЛЭГ АВАГЧ БҮЛГҮҮДИЙН ҮУЛЗАЛТ

МОНЭС нь 2005 оноос эхлэн ХААН Банктай хамтран Улаанбаатар хотын 23 салбарт “хандивын хайрцаг” байрлуулж хандив цуглуулж байгаа билээ. ХААН Банкны үйлчлүүлэгчдийн хандив эмэгтэйчүүдийг чадваржуулахад хэрхэн тусалсныг дүгнэх үүлзалтыг 2008 оны 10-р сард зохион байгууллаа.



Уулзалтын үеэр хэрэгжүүлсэн төслийнхээ үр дүнг хандивлагч нарт танилцуулж, хандивын хайригаар хамгийн их хандив цуглуулсан ХААН банкны Баянгол, Бага тойруу, Чингэлтэй салбаруудад талархал илэрхийлсэн ба ХААН Банк Сангаас эмэгтэйчүүдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд зориулж бидэнд 2,0 сая төгрөгийг хандивласан юм.



ТЭТГЭЛЭГ АВАГЧ БАЙГУУЛЛАГА, БҮЛГҮҮДЭД ЗОРИУЛСАН “КЕЙС БИЙ БОЛГОХ НЬ БҮЮУ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ҮНЭЛЭХ НЬ” ГАРЫН АВЛАГА

Монголын эмэгтэйчүүдийн сангаас тэтгэлэг авагч байгууллага, бүлгүүдийн хэрэгжүүлсэн төслийн үр дүн болон үр нөлөө, гаргасан өөрчлөлт, учирсан бэрхшээл, боломжуудыг өөрсдөө үнэлэхэд тус болох зорилгоор энэхүү гарын авлагыг боловсруулан



гаргасан юм

Кейс бий болгох аргачлал нь төсөл хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх талуудад өөрсдийн жишээн дээр тулгуурлан үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг амжилттай танилцуулах боломж олгодогоороо оншлог юм. Энэ аргачлал нь:

- Нийгмийн өөрчлөлтийн нотолгоонуудыг нэг дор харуулах боломжийг олгодог.
- Үян хатан учир ямар ч төрлийн төсөлд үнэлгээ хийж болохоос гадна чадавхи бэхжүүлэхэд хэрэглэх ч боломжтой.
- Нийгмийн өөрчлөлтийг хэрхэн хэмжих вэ гэдгийг зааж өгөх учир төсөл хэрэгжүүлж байгаа байгууллагын хувьд сургалтын хэрэгсэл болдог юм.

АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГА, БҮЛГҮҮДЭД ЗОРИУЛСАН “ХЭРХЭН ХӨРӨНГӨ БОСГОЖ САН БҮРДҮҮЛЭХ ВЭ?” ГАРЫН АВЛАГА

МОНЭС-гаас

ашгийн төлөө бус зорилгоор ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын санхүүгийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор ТББ-уудад нэн хэрэгшээтэй мэдээлэл болох хөрөнгө босгох

шинэ санаа, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, анхан шатны жижиг төслийд мөнгө олох арга зам, донор байгууллагуудтай харилцаа холбоо тогтооход анхаарах асуудал зэрэг мэдээллийг энэхүү гарын авлагад нэгтгэн боловсруулсан.

Тус гарын авлагыг Дэлхийн

Эмэгтэйчүүдийн Сангаас гаргасан “Сан бүрдүүлэх чадавхи бэхжүүлэх гарын авлага” номноос орчуулан олон нийтэд хүргэж байгаа бөгөөд уг номноос иргэний нийгмийн байгууллагууд сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, санхүүжилтийн тэтгэлэг олох арга зүйн туслацаа авах боломжтой.





ТЭТГЭЛЭГ АВАГЧДЫН АМЖИЛТААС



**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ
ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХАМТАРСАН БАГ
ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ.**

Дархан-Уул,Өвөрхангай аймаг болон Багануур дүүрэгт Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа нэмэгдлээ. Өвөрхангай аймаг, Багануур дүүрэгт “Хүүхэд, гэр бүл зөвлөгөө өгөх төв” байгуулан, үйл ажиллагаагаа эхлүүлж, зардлыг орон нутгийн төсөвт тусгажээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудал дээрх аймгуудын Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагджээ.


Д охиных төрсөн энэг нь хүчирхийлж байсан мэдээллийг бэр эгч Б нь хуулийн байгууллагад хандан асуудлыг шийдвэрлүүлж, хүчирхийлэгч этгээдэд зохих хариуцлагыг нь ноогдуулсны дараа хүчирхийлэгчийн ах дүү хамаатан Б-г “гэр бүлийн нэр хүндийг унагаалаа, чамаас болж гэр бүл салж байна” гэх мэтээр байнга дарамтлах болсон. Мөн нөхөр нь түүнийг байнга зодож, гэр орондоо байх нөхцөлгүй болгожээ. Хэнд хандахталаартодорхоймэдээлэлгүй байсан Б хорооноосоо Хамтарсан багийн тухай сонсож, тэдэнд ханджээ. Хамтарсан багийн гишүүд Б-гийн гэр бүл, хамаатан садантай хэд хэдэн удаагийн уулзалтыг хийж, “ямар учир тухайн хүн шийтгүүлсэн, хүчирхийлэлд өртсөн охинд энэ

нь ямар хор уршигтай болох, энэ асуудлыг мэдээлэх нь тухайн хүний үүрэг байсан” гэлгийг ойлгуулан тэдний хоорондын үл ойголцолыг арилгахад хамтран ажилласан юм. Уулзалтуудын дараа Б-д ирэх дарамт багасч, тэрээр аажмаар хэвийн амьдралдаа эргэн оржээ.



БИ ТА НАРТАЙ ХОЛБОГДООГҮЙ БОЛ ЯХ БАЙСАН БОЛОВ ОО?

Энэ үгийг ХЭҮТ-ийн хамгаалах байраар үйлчлүүлсэн нэгэн эмэгтэй бидэнд хэлсэн юм. Тэрээр анх нөхрийнхөө хүчирхийлэлд өртөж, тэсэхийн аргагүй болсон учир орон нутгийнхаа Хүчирхийлийн эсрэг Үндэсний төвийн салбараар дамжуулан Хамгаалах байранд байрласан юм.





Тэрээр З охинтой. Нийгмийн ажилтан, түүнтэй ярилсанаахаа дараа охидуудтай нь уулзах саналыг тавьжээ. Охидтай уулзах явцад эзэг нь охидыг бага наснаас нь хүчирхийлж байсныг тогтоолоо. Хүчирхийлэгчийн асуудлыг шийдтэл охидыг Хүүхдийг хамгаалах байранд байрлуулж сэтгэл зүйн зөвлөгөө өгч, дэмжих бүлэгт хамрууллаа. Охид амьдарч байсан газартаа дахин эргэн очихыг хүсээгүй учир төвийн ажилтнууд сургууль болон амьдрах газрыг нь өөрчлөхөд тусалж, охидыг хэвийн амьдралд нь эргүүлэн ороход дэмжлэг үзүүллээ. Өнөөдөр охидын сэтгэлийн шарх бага боловч аньж, урьд огт дуугардаггүй байсан охины нүүрэнд хааяа нэг инээмсэглэл тодрох нь эхийн сэтгэлийг баясгаж, харанхуй байсан амьдралд нь гэрэл гэгээ туслаа.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН НҮДЭЭР, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮЧЭЭР

2005 оноос эхлэн дөрөв дэхь жилдээ зохион байгуулж байгаа "Эмэгтэйчүүдийн хүчээр, эмэгтэйчүүдийн нүдээр" Чуулган эмэгтэйчүүдийн хөдөлгөөний төлөвшлийн сул ба давуу талыг үнэлэн дүгнэлээ. Чуулганда 300 гаруй эмэгтэй оролцож, эмэгтэйчүүдийн алсын хараа, эрхэм зорилго болон бодлогын зорилтуудыг нэгтгэн тодорхойлж, үндэсний хэмжээнд хамтын ажиллагаа, уялдаа холбоогоо бэхжүүлэх стратегийг хэлэлцэн, санал бодлоо солилцноос гадна анхаарал татсан нийгмийн асуудлуудыг хөндөн хэлэлцэн юм.



Чуулганаасэмэгтэйчүүдийн хөдөлгөөний баримтлах стратеги чиглэлийг тодорхойлсон нь энэ удаагийн Чуулганы гол үр дүн байлаа.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХАМТЫН ХҮЧ ӨӨРЧЛӨЛТИЙГ АВЧИРНА

Завхан аймгийн эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын "Өрнөххөгжил" Сүлжээ байгуулагдаж байсан цаг саяхан. Сүлжээ



гишүүдээ чадваржуулах, эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийлээс хамгаалах, орлогыг нэмэгдүүлэхээр хамтран ажиллаж эхэлсэн цаг нэгэнт ард хоцорчээ. Энэ хугацаанд хамтран ажиллах нь хамгийн үр дүнтэй гэдэг дээр бүгд санал нэгдсэн ба шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүд хэдийчинээ олон байх тусам, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд эмэгтэйчүүд оролцох нь төдийчинээ үр дүнтэй гэдэг үүднээс 2008 оны орон нутгийн сонгуульд эмэгтэй нэр дэвшигчдээ дэмжиж ажилласан юм. Үүний үр дүнда Завхан аймагт Иргэдийн төлөөлөгчдийн хуралд 9 эмэгтэй сонгогдсон нь нийт төлөөлөгчдийн 29, 0 хувийг эзлэх болжээ. Мөн Засаг даргын орлогч болон 4 сумын Засаг даргаар эмэгтэйчүүд томилогдсон байна.

ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД ЭМЭГТЭЙЧҮҮД ХЯНАЛТ ТАВЬЖ БАЙНА

Өвөрхангай аймгийн "Орон нутгийн санаачлага" төрийн бус байгууллага 2007 оны сүүлчээр аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төв /БОЭТ/- ийн



Зөвлөн эдлэл, нормын хувцасны төсвийн зарцуулалтад мониторинг хийсний үр дүнд төв нь зөвлөн эдлэл, нормын хувцасны 85-90 хувийг Улаанбаатар хотоос худалдан авч байсан тухай мэдээлэл иргэдэд ил тод нээлттэй болсон байна. Үүнийг Улаанбаатараас худалдан авахгүй, орон нутгийнхаа эмэгтэйчүүдээр хийлгэж гүйцэтгүүлбэл тэдний орлого нэмэгдэх төдийгүй ажлын байртай болох боломж байна гэдгийг эмэгтэйчүүдэд харуулж, төрийн бус байгууллага, эмэгтэйчүүд хамтран ажиллаж эхэлсэн юм. Оёдол эрхэлдэг 45 эмэгтэйд төсөвт байгууллагууд худалдан авалт хийх тендерт хэрхэн оролцож болох талаар сургалт явуулж, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлжээ. Нутгийн захирагаа, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын “Гурван талт түншлэл” уулзалтаар энэ асуудлыг хэлэлцэж, эхний ээлжинд БОЭТ-ийн зөвлөн эдлэлийг орон нутгийн оёдолчид оёхоор болжээ.

ФИЛАНТРОПЧДЫН ӨРГӨСӨН ХАНДИВААР 57 ЭМЭГТЭЙН ӨРХИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭЭ

Өрх тэргүүлсэн, ажилгүй, олон хүүхэдтэй, насаар болон хүйсээр ялгаварлагдаж буй давхар давхар



бэрхшээлтэй

эмэгтэйчүүдийг идэвхжүүлэх, багаар хамтран ажиллах чадварыг хөгжүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, амьдрах орчиндоо зэрэг өөрчлөлт авчрах зорилгоор 57 эмэгтэй төсөлд хамрагдсан. Төсөлд хамрагдсан эмэгтэйчүүд барилгын засал чимэглэл хийх, ногоо тарих, иргэдээс хогийг ангилан худалдан авах, тахианы аж ахуй эрхлэх, бэлэг дурсгалын зүйл хийж сурсан 57 эмэгтэй хөдөлмөрөө хоршин, хамтран ажиллах замаар сарын дундаж орлогоо 12000-45000 төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Хан-Уул дүүргийн 14-р хороо буюу бидний нэрлэж заншсанаар Өлзийт хороолол ажилгүй эмэгтэйчүүд олон бий. Тэдний нэг нь Эрдэнэчимэгийнх. Тэрээр гурван хүүхэдтэй ба урьд өмнө хашаандaa ногоо тарьж, хүнсэндээ хэрэглэдэг байлаа. Харин энэ удаа тэрээр Нар хур шим холбоноос зохион байгуулсан ногоо тарьж, ургуулж, арчлах сургалтад суралцаж, ажлын багажаар хангагдаж мөн зөвлөх багштай боллоо. Тэдний ногооны талбайн хөрс тийм ч сайн биш. Ийм нөхцөлд арвин ургац авах гэдэг нь түүнд тийм амар байсангүй. Зуны турш ногооны талбайдаа ажиллана. Багш нь байнга ирж зөвлөгөө өгнө. Олон ч сайхан найзтай болж, эмэгтэйчүүд ч хоорондоо үүлзэлдаж хэрхэн арвин ногоо авах, орлогоо хэрхэн нэмэгдүүлэх талаар ярилцана. Намар болж, төсөлд хамрагдсан эмэгтэйчүүд нийт 1,8 тонн ургац хураан, ургацынхаа баярыг хийж, орлогоо тооцож үзэхэд өрхийн дундаж орлого 18 000-20 000 төгрөгөөр нэмэгдсэн байна.

2008

ОНД ОЛГОСОН ТЭТГЭЛЭГҮҮД

МОНЭС-гийн тэтгэлэг олгох хөтөлбөрийн стратеги чиглэлийн дагуу 2008 онд эмэгтэйчүүдийн 19 төрийн бус байгууллагуудын сүлжээ, байгууллага, бүлгүүдэд нийт 108 917 320 төгрөгний тэтгэлэг олголоо.

1. ЖЕНДЕРТ СУУРИЛСАН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БА ХҮЧИРХИЙЛЛЭЭС ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв, Дархан-Уул, Овөрхангай аймаг, Багануур дүүргийн Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвийн салбар

Тэтгэлэгийн санхүүжилт: 23 692 500 төгрөг.
Гэр бүлийн хүчирхийллэлтэй тэмцэх тухай хуулийн талаар олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, хохирогч наарт зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх

“7-р сарын 1” Эвсэл

Тэтгэлэгийн санхүүжилт: 420 000 төгрөг.
2008 оны 07-р сарын 01-ний өдөр болсон олон нийтийг хамарсан үймээнээс хүний улс төрийн эрх, эрх чөлөө зөрчигдэж байгааг, шийдвэр гаргагчид болон олон нийтэд танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулах

Глоб Аарт ТББ

Тэтгэлэгийн санхүүжилт: 1 492 000 төгрөг.
Ураг төрлийн хүчингийн талаар олон нийт, охид, эмэгтэйчүүдийн ойлголтыг нэмэгдүүлэх

“Иргэдийн Альянс төв”

Тэтгэлэгийн санхүүжилт: 1 575 545 төгрөг.
НҮБ-ын дэргэдэх ЭЯГБХҮТ Конвенцийн хороонд тавих Сүүдэр илтгэлийг бичихэд шаардагдах мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийж, илтгэл бичих бэлтгэлийг хангах

Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвийн Хүүхэд хамгааллын нэгж

Тэтгэлэгийн санхүүжилт: 17 550 000 төгрөг.
Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх

2. ДАВХАР БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЧАДВАРЖУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

“Нар хур шим төв” холбоо, “Насны дэм төв”, “Хөгжлийн хэлхээ” төрийн бус байгууллага, Сонгинохайрхан дүүргийн 8-р хорооны “Сондор” бүлэг, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4-р багийн “Жаргалан” эмэгтэйчүүдийн бүлэг

Тэтгэлэгийн санхүүжилт: 4 967 250 төгрөг.
Өрх тэргүүлсэн, ажилгүй, олон хүүхэдтэй, нас, хүйс зэргээр ялгаварлагдаж буй давхар бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн, багаар хамтран ажиллах чадварыг хөгжүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх,

Ховд аймгийн Мянгад, Жаргалант сумын эмэгтэйчүүдийн бүлэг

Тэтгэлэгийн санхүүжилт: 3 340 000 төгрөг
Алслагдмал бүс нутагт амьдарч байгаа өрхийн орлого багатай эмэгтэйчүүдийг чадавхижуулах

"Гүнж" төв

Тэтгэлэгийн санхүүжилт: 16 152 390 төгрөг
Хүнд нөхцөлд амьдардаг жирэмсэн болон хүүхэд төрүүлсэн өсвөр насны охид, тэдний хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх

3. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОOG НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

Эмэгтэй удирдагч сан

Тэтгэлэгийн санхүүжилт: 7 457 135 төгрөг.
“Нийгмийн асуудал ба манлайлагч эмэгтэйчүүд” Үндэсний Чуулган зохион байгуулах

Дархан-Уул аймгийн ЭТББ-ын сүлжээ

Тэтгэлэгийн санхүүжилт: 2 514 750 төгрөг.
Орон нутгийн сонгуульд нэр дэвшиж буй эмэгтэйчүүдийг дэмжих

Завхан аймгийн “Өрнөх хөгжил” ЭТББ-ын сүлжээ

Тэтгэлэгийн санхүүжилт: 2 350 000 төгрөг
Орон нутгийн сонгуульд нэр дэвшиж буй эмэгтэйчүүдийг дэмжих

4. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын Үндэсний сүлжээ, Эмэгтэй удирдагч сан, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо

Тэтгэлэгийн санхүүжилт: 1 823 900 төгрөг
Эмэгтэйчүүдийн нүдээр, эмэгтэйчүүдийн хүчээр” Чуулганыг зохион байгуулах

Дундговь аймгийн эмэгтэйчүүдийн нэгдсэн холбоо

Тэтгэлэгийн санхүүжилт: 2 564 000 төгрөг
Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын хамтран ажиллах чадварыг хөгжүүлэх, чадавхжуулах

Дархан-Уул, Дундговь, Ховд аймгийн ЭТББ-үүд

Тэтгэлэгийн санхүүжилт: 2 785 370 төгрөг
Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын гишүүдийг чадваржуулах сургалтуудууд зохион байгуулах

“Хамтлагийн хөгжил”

Тэтгэлэгийн санхүүжилт: 3 000 000 төгрөг.
Сүлжээний гишүүдийн чадавхийг бэхжүүлэх

Багануур дүүргийн ЭТББ-ын сүлжээ


Тэтгэлэгийн санхүүжилт: 3 000 000 төгрөг
Зүүн бүсийн эмэгтэйчүүдийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх



САН БҮРДҮҮЛЭХ ҮЙЛ

АЖИЛЛАГАА

Энэ үйл ажиллагааны зорилго нь эмэгтэйчүүдийн эрхэд суурилсан нийгэмд үйлчилдэг эмэгтэйчүүдийн ТББ ба бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжихийн тулд дотоод, гадаадын эх үүсвэрээс сан бүрдүүлиэ.




БИД ДАРААХ АСУУДЛЫН ТӨЛӨӨ ХӨРӨНГӨ БОСГОДОГ

1. Охид, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгахад,
2. Аливаа хэлбэрийн хүчирхийлэл, түүний дотор бэлгийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад,
3. Олон хүүхэдтэй, өрх тэргүүлсэн, орлогогүй, эсвэл хөгжлийн бэршээлтэй, нийгмийн хөгжлөөс хоцорч гадуурхагдсан зэрэг давхар давхар бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийг чадавхжуулж хөгжүүлэхэд,
4. Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшинд оролцох оролцоог нэмэгдүүлэх,
5. Эмэгтэйчүүд, тэдний байгууллага бүлгүүдийн тогтвортой хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг дэмжихийн тулд бид хувь хүмүүс, байгууллага, олон улсын байгууллагуудаас санхүүгийн нөөц хөрөнгийг хуримтлуулж төслийн санхүүжилт хийдэг.

2008 онд дотоод эх үүсвэрээс 10,84 сая тогрог, гадаад эх үүсвэрээс 203,72 сая тогрог, нийтдээ 214,57 сая төгрөгийн сан бүрдүүллээ.

ДОТООД САН БҮРДҮҮЛЭЛТ



**ОЛОН УЛСЫН
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ
ХАМГААЛАХ ӨДӨР**
03.08

“Эмэгтэйчүүдийн нүдээр, эмэгтэйчүүдийн хүчээр”
Эмэгтэйчүүдийн ТББ-дын Үндэсний чуулганы үеэр Эмэгтэйчүүдийн эрхийн төлөө үйлсэд нэгдэхийг уриалж сан бүдүүлэх кампанит ажлыг зохион байгууллаа.





2008.12.10 - 2009.03.08

ХУНИЙ ЭРХИЙН ЕДРЭС
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙН ЕДЕР ХҮРТЭЛ

“ОХИД ЭМЭГТЭЙЧҮҮДИГТ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЭС ХАМГААЛЬЯ”


Сан бүрдүүлэх кампант ажил эхэллээ

**Та бүхэн 88 өдрийн
аянд хандив өргөнө үү !**


ХАНДЫВЫН ДАНС: ХААН Банк 5031039208
Монголын Эмэгтэйчүүдийн Сан

Утас: 317904, 99056817
E-mail: mones@mongol.net | web: mones.org.mn

“Охид, эмэгтэйчүүдийг бэлгийн
хүчирхийлээс хамгаалья”
уриан дор 88 өдрийн сан
бүрдүүлэх аянг 4 дэхь жилдээ
зохион байгуулав.
12.10-03.08



Аяны хүрээнд Оскарын шагналт
кино найруулагч Беверли
Шафферийн бүтээл “Аюулгүй
газар руу” баримтат
кино хэлэлцүүлгийг охид
эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн
хүчирхийллийн асуудлаар
олон нийтийн дунд зохион
байгууллаа.



Киноны билетны таксаас 2 270 280,00
төгрөгний сан бүрдүүллээ.



Орхон аймаг /88 өдрийн аяны үйл
ажиллагаа/



Төв аймаг /Ахлах ангийн сурагчдын дунд
кино хэлэлцүүлэг/



ХАНДИВЫН ХАЙРЦАГНЫ АЯН

2005 оноос “Өрх тэргүүлсэн олон хүүхэдтэй эхчүүдийн орлогыг нэмэгдүүлж, ядуурлаас гаргая” уриан дор хандивын хайрцаагаар хандив цуглуулж байна. Энэ хайрцааг ХААН банкны 23 салбарт байрладаг ба банкны үйлчлүүлэгч иргэдийн хандивласан мөнгө жилээс жилд нэмэгдэж байна. Мөн ХААН банк нийгмийн төлөө хувь нэмэр оруулдаг өөрийн сангаасаа бидэнд хандив өргөдөг боллоо.

Нэг хүний тус мэгее хүний амьдралыг сөрчлөх агуу их хүчтэй.

Монголын Эмэгтэйчүүдийн Сан


Та таван хүүхдийн тэлээмжийн мэргэжлийн 25 000 төгрөгөөр бүтэн сарын түрш хүүхдүүдээс явахаа тэжээжчадах уу?

Та хандив өргөнө ўу!

ТАНЫ брэгсийн хандив:
урх толгойлон олон хүүхэдтэй эхж нарт гарзэр хөдөлмөр эрхлэхэд нь зориулагдах болно.

Хэрвээ та хандиваа дансаар шилжүүлэв:

Даншигч байгууллага: Хуудамжийн эмэгтэйчүүдийн Сангийн Сонсогийн Банк
ХААН БАНК
Даншиг дугаар: 503 103 92 08
www.mones.org.mn e-mail: mones@mongol.net утас: 317804, 99056817



ТАЛАРХАЛ

Монголын эмэгтэйчүүдийн хөгжил дэвшил, нийгмийн сайн сайхны төлөө хандив цуглуулах үйлсэд идэвхитэй оролцож, халуун сэтгэлийн өглөг буянаа зориулж байдаг ХААН Банк Сан, ХААН Банкны хамт олон, тус банкны байнгын үйлчлүүлэгчид Эрхэм хандивлагчид Та бүхэндээ МОНЭС-ийн хамт олны нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархлаа илэрхийлье.



ХААН БАНК

**Филантропи одруүгдээр
5 төрлийн багц арга
хэмжээ зохион байгуулжс
35 байгууллага 106 хувь хүн
оролцож 1721750 тогрогийн
хандив шуглуулав.**

НЭГ ХҮНИЙ ТУС НӨГӨӨ ХҮНИЙ АМЬДРАЛЫГ
ӨӨРЧЛӨХ АУГАА ИХ ХҮЧТЭЙ!

**Олон Улсын
Филантропи
өдрийн аян**

2008.11 сарын 15-30

**Өрх тэргүүлсэн, олон хүүхэдтэй эхчүүдийг
хөдөлмөр эрхлүүлж ядуурлаас гаргахад**

ХАНДИВ өргөгөө!

МОНЭС
Монголын энзэтгэчийн нийтийн сан

ХАНДИВЫН ДАИС:
Банкны нэр: ХААН Банк
Хүргэх санч байгууллагат: Монголын Энзэтгэчийн сан
Дансны дугаар: 5631039208

Утас: 317904, 99056617 | e-mail: mones@mongol.net | web:mones.org.mn

Олон Улсын Филантропи өдрийг 6 дахь жилдээ тэмдэглэн өнгөрүүлэв
Энэ өдрийг “Өрх тэргүүлсэн олон хүүхэдтэй ээжүүдийг хөдөлмөр эрхлүүлж, ядуурлаас гаргахад хандив өргөнгөө” гэсэн уриан дор сан бүрдүүлэх кампанит ажил зохиов.
(11 сарын 15-30)

Аяны хүрээнд:

- Филантропчдын уулзалт цэнгүүнийг зохион байгуулав. Үүнд МОНЭС-ийн хандивлагчид, тэтгэлэг авагч бүлгүүд, хэвлэл мэдээллийн болон урлаг соёлын одод оролцов.



- Өмнөх оны Филантропи өдрөөр олгогдсон төслийн тайланг танилцуулав. Филантропчдын өргөсөн хандиваар өрх тэргүүлсэн 57 эхчүүдийн орлогыг нэмэгдүүлээ.
- Олон Улсын Филантропи өдрийн мэндчилгээг нийт филантропчидод дэвшүүлэв. Филантропчдын уулзалт цэнгүүнд Монгол Улсын Гавьяат жүжигчин А.Чаминчулуун, С.Батсүх, СУИС-ийн багш М.Одонтuya нар уран бүтээлийн дээжээс бэлэг барьлаа.
- Филантропич хамт оныг шалгаруулан урамшуулав.

Нийгмийн төлөө Филантропч хамт олноор:

- Ж.Питер Морроу Гүйцэтгэх захиралтай ХААН Банкны хамт олон
- Т.Лхамгарав даргатай “Эрдэнэт үйлдвэр” ХХК –ий Эмэгтэйчүүдийн зөвлөл
- Д.Дуламсүрэн даргатай Орхон аймгийн эмэгтэйчүүдийн Зөвлөлийн хамт олон тус тус шалгарлаа.

ТАЛАРХАЛ:

Билний үйл хэргийг дэмжиж,
эмэгтэйчүүдийн хөгжил
дэвшилд хувь нэмэр оруулж
байгаа хандивлагч хувь
хүмүүс, байгууллага хамгийн
олонд МОНЭС-ийн нэрийн
өмнөөс чин сэтгэлийн талархал
илэрхийлж байна.

САН БҮРДҮҮЛЭХ ХУДАЛДАА:

МОНЭС-ийн брэнд аягыг
УИД, Скай худалдааны
төвүүдийн бэлэг дурсгалын
тасагт худалдаалж байна.



МӨНГӨН БУС ХЭЛБЭРЭЭР ХАНДИВ ӨРГӨСӨН БАЙГУУЛЛАГУУД

Ийгл телевиз, С1 телевиз, МҮОНТ, SBN телевиз, Өдрийн сонин, Зууны мэдээ сонин, Эрэгтэйчүүд Эмэгтэйчүүд Сэтгүүл, Монголын нэг дөр сонин, Үнэн сонин, Гэр бүлийн радио Салхи-104.5, Инээмсэглэл ФМ радио, Соёмбо принтинг, ХААН Банк галерей, Иргэдийн Альянс Төв, МОНФЕМНЕТ, ХЭҮТ-ийн Хүүхэд хамгаалал нэгж, Гүнж төв, Хүйсийн тэгш эрхийн төв, Монголын Эмэгтэйчүүдийн холбоо, Орхон аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөл, Төв аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөл, “Эрдэнэт” үйлдвэрийн Эмэгтэйчүүдийн Зөвлөл, Зонта Интернешнл клуб, Ардчлалын Боловсролын төв, Хууль ба хүний эрх төв ТББ, Дүүрэн санаа ТББ, Нар хур шим холбоо,

МӨНГӨН БУС ХЭЛБЭРЭЭР ХАНДИВ ӨРГӨСӨН ХУВЬ ХҮМҮҮС:

Азийн Хөгжлийн Банкны Жендерийн мэргэжилтэн; МОНЭС-ийн УЗГ Б.Оюунбилэг, МУГЖ С.Батсүх, МУГЖ Л.Чаминчулуун, СУИС-ийн багш М.Одонтuya; Public PR ТББ-ийн захирал, зохиолч Б.Тогтохбаяр; сэтгүүлч МОНЭС-ийн УЗГ Н.Дуламсүрэн, МАОЭНХолбооны сургалтын багш Б.Эрдэнэцэвтэг;

САН БҮРДҮҮЛЭХ “НАЙЗЫН СҮЛЖЭЭ” ҮҮЛЗАЛТ

Манай ажилтнууд өөрсдийн
найзуудаа цуглуулан
байгууллагынхаа үйл ажиллагаа
хэрэгжиж буй төслүүдийг
танилцуулж дүгүй ширээний
үүлзалт зохион байгууллаа.
Үүлзалтаар 534 130 төгрөгийн
хандив цуглуулав.



**МОНЭС-ГААС ТЭТГЭЛЭГ АВСАН
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН СЭТГЭГДЭЛ**
**Д.Амарсайхан, Нар хур Шим
Холбоо ТББ-ын Гүйцэтгэх
захирал:**

МОНЭС-ийн хандивлагч нарт
чин сэтгэлийн талархалаа
илэрхийлэхийг хүсэж байна.
Та бүхний хандивласан мөнгийг
манай байгуулага хүлээн авч
одоогоор 15 эмэгтэй ажилтай
олж, өрхийн орлогоо 18000-
20000 төгрөгөөр нэмэгдүүлсэн.
Мөн хүүхдүүдийнхээ хоол
хүнсэнд санаа зовохооргүй болж
чадсан. Та нарт дахин баярласнаа
илэрхийлье.



МОНЭС-ИЙН САЙН ДҮРҮН АЖИЛТАН

**Б. Эрдэнэшогт,
МАОЭНХ-ны сургагч багш**
Тэрээр 2006 оноос сайн дураараа
МОНЭС-ийн сан бүрдүүлэх үйл
ажиллагаанд өөрийн цаг завыг
зориулан жил бүр давхардсан
тоогоор 106 хүнээс 257 000
төгрөгний хандив цуглуулж өгсөн.



МОНЭС-ИЙН ХҮНДЭТ ХАНДИВЛАГЧ

**Жадамбын Лхам
“Мөнгөн зүү” Эмнэлэгийн
эмч**
Ж.Лхам жил бүр өрх
тэргүүлсэн олон хүүхэдтэй
эхчүүдэд туслах үйлсэд
зориулан “Мөнгөн зүү”
эмнэлэгийн орлогын тодорхой
хувийг МОНЭС-д хандивладаг.





ОЛОН УЛСЫН СҮЛЖЭЭ, ХАМТЫН АЖИЛЛАГАА



**Манай сан Олон Улсын
байгууллага, сангудын
сүлжээний гишүүн юм. Бид
үйл ажиллагаагаа хөгжүүлэх
боловд хөрөнгө нөөцийг бий
болгох, нийгэмд өөрчлөлт
оруулахуйц алхамууд хийхэд
эдгээр байгууллагуудын туршлага
ихээхэн хувь нэмэр болдо.**



Азийн бүсийн Эмэгтэйчүүдийн Сангудын
Сүлжээний уулзалт, 2008 оны 3 сар,
Энэтхэгийн Бубанише хотод боллоо.



Азийн бүсийн Эмэгтэйчүүдийн сангудын
туршлага судлах аялал, 2008 оны 10 сар
Хонг Конг,

Сүлжээ байгууллагууд:

- » ОУ-ын Эмэгтэйчүүдийн Сангудын Сүлжээ /INWF/
- » Америкийн Эмэгтэйчүүдийн Сангудын Сүлжээ /WFN/
- » Азийн Эмэгтэйчүүдийн Сангудын Сүлжээ /AWFN/
- » Хөгжлийн төлөө Эмэгтэйчүүдийн Олон Улсын холбоо /AWID/
- » Хил хязгааргүй тэтгэлэг олгогчдын Сүлжээ /GWOB/
- » Хүний эрхийн Сангудын Сүлжээ /HRFN/




Дэлхийн Эмэгтэйчүүдийн Сангудын
Сүлжээний хурал, 2008 оны 5 сар, АНУ,
Вашингтон хот



Хөгжлийн төлөө Эмэгтэйчүүдийн Олон
Улсын Холбооны Форум, 2008 оны 11 сар
Өмнөд Африк,

ХАМТ ОЛОН



УДИРДАХ ЗӨВЛӨЛ:

Б. Оюунбилэг
С. Төгс-Оюун
Ш. Оюунгэрэл
Н. Дуламсүрэн
Ш. Солонго
Х. Хулан
С. Оюунчимэг
Д. Наран

Д.Оюунцэцэг
Б.Наранцэцэг
Л.Амарзаяа
Б.Мандухай
Ө.Сарантуяа
А.Энхцэцэг
С.Дондов
Д.Нэргүй

ЗӨВЛӨХ ГИШҮҮД:

Dian Van Maasdijk
Dr. Sheldon Severinghaus
Mary Rossabi

ГҮЙЦЭТГЭХ АЛБА:

Н.Чинчулуун
/Вахирал/
chinchee@mones.org.mn

Л.Болор
/Гадаад харилцаа,
гадаадаас сан бүрдүүлэх
зохицуулагч/
bolor@mones.org.mn

Б.Эрдэнэчимэг
/Тэтгэлэг олгох
хөтөлбөрийн зохицуулагч/
chimgee@mones.org.mn

М.Мэндбаяр
/Сан бүрдүүлэх хөтөлбөрийн
зохицуулагч/
mendeet@mones.org.mn

Б.Байгалмаа
/Сан бүрдүүлэлт,
маркетингийн зохицуулагч/
baigal@mones.org.mn

П.Даваанамжил
/Санхүү, нягтлан бодогч
davaa@mones.org.mn

Ч.Саранчимэг
/Дотоод ажлын зохицуулагч/
admin@mones.org.mn

